



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын
2024 оны 3 дугаар сарын 9 ны өдрийн
A/42 тушаалын дөрөвдүгээр хавсралт



**№ 07.3.1 АЖИЛТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫГ
ШАЛГАХ ХЯНАЛТЫН ХУУДАС**

ИХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН НЭР /

Утас: _____

Цахим хаяг: _____

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хяналт шалгалт эхэлсэн: 20__ он __ сар __ өдөр, __ цаг __ мин;

Дууссан: 20__ он __ сар __ өдөр, __ цаг __ мин;

Хяналт шалгалтын төрөл _____ Удирдамж _____

Төлөвлөгөөт хяналт шалгалт
Урьдчилан сэргийлэх хяналт
шалгалт

Дугаар:
Нэр:

Аж ахуйн нэгж байгууллагын
нэр: _____ Регис
трийн
дугаар _____
Хаяг, байршил _____

Даатгуулагчийн мэдээлэл	
Нийт даатгуулагчийн тоо	
Хөдөлмөрийн гэрээтэй даатгуулагчийн тоо	
Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа	
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн даатгуулагчийн тоо	
Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тоо	
Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгосон	
Хүүхэд асрах чөлөөтэй даатгуулагчийн тоо	
Ажлаас чөлөөлөгдөн суралцаж байгаа даатгуулагчийн тоо	
Нэг ба түүнээс дээш сарын хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан даатгуулагчийн тоо	

Шаардлага хангасан асуултын тоо:

Хууль сахин мөрдөлтийн хувь:

Эрсдэл үүсэх магадлал:

Шаардлага хангаагүй асуултын оноо:

Эрсдэл үүсэх магадлалын хувь:

Б. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

№	Хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын нэр, зүйл, заалт	Асуултууд	Батлагдсан оноо		Авсан оноо	Гүйцэтгэлийн хяналт шалгалт
			Шаардлага хангасан	Шаардлага хангаагүй		
	1	2	3	4	5	6
Нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр						
1	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалт	Хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтнуудыг нийгмийн даатгалд бүрэн хамруулсан эсэх;	0	50		

2	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.2 дахь заалт	Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд, аж аухйн нэгж байгууллага, төлөөний газарт ажиллаж байгаа ажилтнуудыг нийгмийн даатгалд бүрэн хамруулсан эсэх;	0	30		
3	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3 дахь заалт	Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллага, гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн нэгж, салбар, төлөөлөгчийн газар, төлөөний газарт ажиллаж байгаа ажилтныг нийгмийн даатгалд бүрэн хамруулсан эсэх;	0	30		
4	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалт	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан эсэх;	0	30		
5	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалт	Ажил олгогч, хүнтэй хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагчийг Тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд даатгуулсан эсэх;	0	30		
6	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.10 дэх заалт	Өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтныг Тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалд бүрэн хамруулсан эсэх;	0	30		
7	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалт	Тэтгэвэр, тэтгэмжийн даатгалд албан журмаар даатгуулах даатгуулагчдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулж, НДШ-ийг хуульд заасны дагуу үнэн зөв тооцсон эсэх;	0	30		
8	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь заалт	Тэтгэврийн даатгалд албан журмаар даатгуулах даатгуулагчдыг нийгмийн даатгалд бүрэн хамруулж, НДШ-ийг хуульд заасны дагуу үнэн зөв тооцсон эсэх;	0	30		
9	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь заалт	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.1-д заасан насанд хүрсэн энэ хуулийн 7.3.4-т заасан тэтгэвэр авагч өөрөө хүсэлт гаргасан тохиолдолд тэтгэврийн даатгалаас чөлөөлсөн	0	30		
10	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалт	Нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогыг үнэн зөв тодорхойлсон эсэх;	0	50		

11	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалт	Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан болон тэдгээртэй адилтгах гэрээгээр тохирсон цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл бүрэн тооцож төлсөн эсэх;	0	30		
12	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалт	Ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшууллаас НДШ бүрэн тооцож төлсөн эсэх;	0	30		
13	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтууд	Нийгмийн даатгалын шимтгэлийг тогтоосон хугацаанд бүрэн төлдөг эсэх;	0	50		
14	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 дэх заалт	7 сараас доошгүй хугацаагаар улирлын шинжтэй ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжийн ажилтнуудын ажиллаагүй хугацааны НДШ-ийг ажил олгогчоос бүрэн төлсөн эсэх;	0	30		
15	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь заалт	Даатгуулагчийн нэг ба түүнээс дээш сарын хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж авч байх хугацааны шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож, сар бүр төлсөн эсэх;	0	20		
16	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6 дахь заалт	Даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж авч байх хугацааны шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож, сар бүр төлсөн эсэх;	0	20		
17	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.7 дахь заалт	Даатгуулагчийн хууль бусаар ажлаас халагдсан хугацааны шимтгэлийг зөв тооцож, төлсөн эсэх;	0	20		
18	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь заалт	Даатгуулагчийн хилс хэргээр мөрдөгдсөн, хорих ял эдэлсэн хугацааны шимтгэлийг зөв тооцож, төлсөн эсэх	0	20		
19	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.9 дахь заалт	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд олгосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, урамшууллаас нийгмийн даатгалын шимтгэл үнэн зөв тооцож төлсөн эсэх;	0	20		
20	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.13 дахь заалт	Ажил олгогчийн захиалгаар суралцаж байгаа даатгуулагчийн шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож, сар бүр төлсөн эсэх	0	20		

21	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлийн 21.14 дэх заалт	Хөдөлмөрийн гэрээтэй эх эсхүл эцгийн хүүхдээ гурван нас хүртэл асрах чөлөөтэй байгаа хугацааны шимтгэлийг тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс тооцож, сар бүр төлсөн эсэх;	0	20		
22	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт	Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг цахим эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулж, нийгмийн даатгалын байгууллагад хугацаанд нь хүргүүлж, тайлагнадаг эсэх;	0	30		
23	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалт	Нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцлийг үнэн зөв гаргадаг эсэх	0	30		
24	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4 дэх заалт	Хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулсан, дуусгавар болгосон талаарх шийдвэр болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой баримт бичгийг тухай бүр нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлдэг эсэх;	0	30		
25	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.4 дэх заалт	Хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулсан, дуусгавар болгосон талаарх шийдвэр болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой баримт бичгийг тухай бүр нь даатгуулагчид өгдөг эсэх;	0	30		
26	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.5 дахь заалт	Нийгмийн даатгалын хууль тогтоомж зөрчсөн зөрчлийг арилгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон акт, шийтгэлийн хуудас, өгсөн албан шаардлага, мэдэгдлийг хугацаанд нь бүрэн биелүүлсэн эсэх.	0	30		
27	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.6 дахь заалт	Ажил олгогчийн буруугаас даатгуулагчид учирсан хохирлыг бүрэн хариуцаж төлсөн эсэх;	0	30		
28	Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.7 дахь заалт	Ажилтныг нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх мэдээллээр хангаж ажилладаг эсэх;	0	30		
29	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 3, 4 дүгээр зүйлүүд	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг хуулийн хугацаанд нь бодож олгодог эсэх	0	20		

30	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалт	Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллагаас хуулийн хугацаанд нэхэмжилж, даатгуулагчид олгодог эсэх	0	20		
31	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуулийн 6, 7 дугаар зүйлүүд	Ажилтны жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг хуулийн хугацаанд нь зөв бодож нийгмийн даатгалын байгууллагаас нэхэмжилж, даатгуулагчид олгодог эсэх;	0	20		
32	Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь заалт	Ахмадын сан байгуулсан эсэх;	0	20		
33	Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь заалт	Ахмадуудад дэмжлэг туслалцаа үзүүлдэг эсэх;	0	20		
34	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх заалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөрлөх эрхийг хангасан эсэх	0	20		
35	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.4 дэх заалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн амьдралын идэвхтэй оролцоо, түүний амжилт, бүтээлийг хамт олонд нь сурталчлах, урамшуулах арга хэмжээг авсан, эсэх;	0	20		
36	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.5 дахь заалт	Хөгжлийн бэрхшээлтэй болсон хүнд түүнийг ажиллуулж байсан байгууллагын хувьд тусламж, дэмжлэг үзүүлдэг, эсэх;	0	20		
37	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.6 дахь заалт	Өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх, үүргийг хүлээж авсан этгээд энэ хуулийн 43.1.5-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлсэн, эсэх;	0	20		
38	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.7 дахь заалт	Хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй зүй бусаар харилцах, эрх, эрх чөлөөг нь аливаа хэлбэрээр зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй гаргадаг, эсэх;	0	20		
39	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1.8 дахь заалт	Ажилтан тухайн байгууллагын буруутай үйл ажиллагааны улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон нь шүүхээр тогтоогдсон, хохирлыг нөхөн төлсөн эсэх;	0	20		
40	Цэргийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолын 1.1 дэх заалт	Сонсогчийн цэргийн сургуульд суралцсан хугацааг нийт ажилласан болон төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцсон эсэх;	0	30		
41	Цэргийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6, ЗГ-ын 2020 оны 151 дүгээр тогтоолын 1. дэх заалт	Хугацаат цэргийн алба хаасан хугацааг нийт ажилласан болон төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцсон эсэх;	0	30		

42	Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь заалт	Үндсэн цалинг Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн 3 талт Үндэсний хороо болон Салбарын хэлэлцээрээр тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүйгээр тогтоож олгодог, түүнээс нийгмийн даатгалын шимтгэл төлдөг эсэх;	0	20		
43	Засгийн газрын 2020 оны 151 дүгээр тогтоолын 1.1 дэх заалт	1990-1995 оны хооронд ажилласан жил тасарсан иргэнд Нийгмийн даатгалын байгууллагаас олгосон баталгаажилтын хуудсыг үндэслэн ажилласнаар нөхөн тооцуулсан хугацааг нийт ажилласан болон төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцсон эсэх	0	30		
44	Засгийн газрын 2023 оны 471 дүгээр тогтоолын 1 дэх заалт	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг төлөх ажил, мэргэжлийн жагсаалт, шимтгэлийн хувь хэмжээ, хэрэглэх журмын дагуу төлсөн эсэх.	0	30		
45	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дүгээр тушаалын 3 дахь хэсэг	Газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд ажиллаж байгаа ажилтны ажил мэргэжлийг "Газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт"-ад нийцүүлэн ажилд томилсон, ажлаас чөлөөлсөн тушаал шийдвэрт тусгадаг эсэх.	0	30		
46	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 2.2.1 дэх заалт	Даатгуулагчийн шимтгэл ногдох орлогыг зөв тооцсон эсэх	0	20		
47	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 2.2.2 дахь заалт	Даатгуулагчид нэгтгэн олгосон цалин хөлс, түүнтэй адилтгах орлого болон ээлжийн амралтын олговрыг уг даатгуулагчийн аль сард ногдох орлого болохыг тодорхойлж харгалзах саруудын НДШ төлөлтийн тайланд тусган тайлагнадаг эсэх	0	30		
48	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 2.2.5 дахь заалт	Тайланд даатгуулагчийн иргэний бүртгэлийн дугаар, эцэг/эхийн нэр, өөрийн нэр, төрлийн код болон бусад мэдээллийг үнэн зөв оруулж тайлагнадаг эсэх	0	20		

49	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 2.2.7, 2.2.8 дахь заалтууд	Тайланд ажил, мэргэжлийн ангиллыг Үндэсний ажил, мэргэжлийн ангилал, тодорхойлолтод заасны дагуу үнэн зөв сонгож тайлагнадаг эсэх	0	30		
50	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 2.2.7, 2.2.8 дахь заалт	Даатгуулагчийн ажилд орсон, чөлөөлсөн, мөн еөрчлөлт орсон тушаалыг тухай бүр шимтгэлийн цахим системд оруулдаг эсэх	0	30		
51	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 13 дугаар зүйлийн 13.1 заалтууд, ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"	Тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, халуун хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлээр ажиллаж байгаа ажилтны тухайн ажилд томилсон, чөлөөлсөн тушаалын хуулбарыг шимтгэлийн тайланд хавсаргаж хүргүүлдэг эсэх;	0	30		
52	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 13 дугаар зүйлийн 13.1 заалтууд, ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"	Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам батлуулан мөрдөж ажилладаг эсэх;	0	50		
53	Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 13 дугаар зүйлийн 13.1 заалтууд, ЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоол "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"	Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлдэг, үр дүнг тогтмол тооцдог эсэх;	0	50		
НИЙТ ОНОО			0	1480	0	

>=50% Их эрсдэлтэй
[30%-49%] Дунд эрсдэлтэй
<=29% Бага эрсдэлтэй

БАТАЛГААЖУУЛАЛТ	
Шалгалт хийсэн: <i>Нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагч</i>	Хүлээн зөвшөөрсөн: <i>Байгууллагын албан тушаалтан</i>
..... <i>/Овог, нэр/</i> <i>/албан тушаалын нэр, овог, нэр/</i>
.....(гарын үсэг, тэмдэг)(гарын үсэг, тамга)

В. ХЯНАЛТ ШАЛГАЛТААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

Оноо	Үнэлгээ	Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад авах арга хэмжээ		Биелэлт
		авах арга хэмжээ	тоон үзүүлэлт	
		а/ Акт		
		•Үйл ажиллагааг бүр зогсоосон		
		•Түр зогсоосон		
		•Сэргээсэн		
		•Нөхөн төлбөр		

	б/ Албан шаардлага /Зөвлөмж		
	•Заалтын тоо		
	в/ Дүгнэлт		
	•Үйл ажиллагааны		
	г/ Нөхөн төлбөрийн хэмжээ,		
	мян/төг		
	д/Торгууль, шийтгэвэр		
	•Хуулийн этгээд: тоо/ мөнгөн дүн		
	•Хүн: тоо/мөнгөн дүн		

Г. ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГАЛТААР АВСАН АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

Хяналт шалгалт эхэлсэн: 20__ он __ сар __ өдөр, __ цаг __ мин;
дууссан: 20__ он __ сар __ өдөр, __ цаг __ мин;

Оноо	Үнэлгээ	Тухайн аж ахуйн нэгж, байгууллагад авах арга хэмжээ		Биелэлт
		авах арга хэмжээ	тоон үзүүлэлт	
		а/ Акт		
		•Үйл ажиллагааг бүр зогсоосон		
		•Түр зогсоосон		
		•Сэргээсэн		
		•Нөхөн төлбөр тогтоосон		
		б/ Албан шаардлага /Зөвлөмж		
		•Заалтын тоо		
		в/ Дүгнэлт		
		•Үйл ажиллагааны		
		г/ Нөхөн төлбөрийн хэмжээ,		
		мян/төг		
		д/Торгууль, шийтгэвэр		
		•Хуулийн этгээд: тоо/ мөнгөн дүн		
		•Хүн: тоо/мөнгөн дүн		
БАТАЛГААЖУУЛАЛТ				
Шалгалт хийсэн: Нийгмийн хамгааллын хяналтын улсын (ахлах) байцаагч		Хүлээн зөвшөөрсөн: Байгууллагын албан тушаалтан		
..... /овог, нэр/	 /албан тушаалын нэр, овог, нэр/		
..... (гарын үсэг, тэмдэг)	 (гарын үсэг, тамга)		